



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 1143

Улаанбаатар хот

Г Хөрөнгө гаргах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5 дахь заалт, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.7.6 дахь заалт, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан зочид буудал, дэн буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтны гарын авлагын эхийг бэлтгүүлж 06 дугаар сарын 30-ны дотор хэвлүүлэхийг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

2. Гарын авлага бэлтгэх, хэвлүүлэх төсвийг хавсралтаар баталсугай.


3. Эхийг бэлтгэх, хэвлэлтэд шаардагдах төсөв 10,000,000 /Арван сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2016 оны 04 сарын 18-ны
өдрийн **А/чз** тоот тушаалын хавсралт



ГАРЫН АВЛАГЫН ЭХ БЭЛТГЭХ, ХЭВЛҮҮЛЭХ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Гарын авлагын эх бэлтгэх	5	500,000	2,500,000
2	Видео хичээл бэлтгэх	5	500,000	2,500,000
3	Гарын авлага хэвлүүлэх	5	1,000,000	5,000,000
	Нийт төсөв			10,000,000